



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/25

Дархан

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 41 дүгээр тогтоол, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралтын 4.5 дах заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 06-ны 02-А/139 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймгаа төлөөлөн оролцох, зохион байгуулах зардалд шаардагдах 7,215,450 (долоон сая хоёр зуун арван таван мянга дөрвөн зуун тавь) төгрөгийг тээвэр шатахууны зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

2. Батлагдсан төсвийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зардлын тооцоо гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт бүрдүүлэхийг Архив-бичиг хэрэг, нярав (Д.Ариунжаргал)-д хариуцуулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (С.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

4524010004